

Эрдэмд зам заасан багш минь

О. Лхагва

МУИС, ФЭС, ОТФТэнхим

Цагийн мөрөн урссаар

Одоо хэмээх үг байх авч “одоо” нь үнэндээ үгүй мэт. Бага залуу насанд “одоог” мөнх л хэмээн санаж явж. Цагийн мөрөн тасралтгүй бас хурдтай урсдаг учраас оюутан ахуй цаг, залуу нас, түшиж явсан ачтан багш нар минь тэртээ ард хоцорчээ.

Цаг хугацаа өнгөрснөөр юм юм хувирч бүдгэрэх авч оюун ухаант хүмүүний хувьд өнгөрсөн гэгээн үйлс сэтгэлийн тэнгэрт тодорч, хүнд сургаж, бүтээх туурвихын дууриал эрч хүч олгодог бололтой. Энд хүндэт эрдэмтэн, академич Батсуурь багшийнхаа тухай дурсаж байна. Дурсамж бол хувь хүмүүсийн харьцаа, хамтын зүтгэл төдийхөн биш, харин ч байгаль, нийгмийн хувьслын жамд цогцолсон бүхэл бүтэн үеийн явц, өнгө аясыг тусгадаг бололтой юм.

Эрдмийн анхны давалгаа

XX зуунд эхэлсэн физик хийгээд нийгэм дэх их салхин Монголын тал нутагт иржээ. Тэр салхинаар “эрх чөлөөгөө” олсон монголчууд малчны хотонд шилбүүрээ орхиод эх орноо мандуулах, эрдмийг бадруулах үйлс лугаа зорьжээ. Тэгснээрээ бидний монголчууд цагийг нараар хэмжиж, хувьслыг 4 улирлаар баримжаалахаа орхиж, хүмүүн төрөлхтний соёл сэтгэлгээний үйлст нэгдэх урсгалыг үүсгэсэн бололтой. Эл урсгалын нэг чиглэл нь физик эрдэм байв. Тэр урсгалын эхний давалгаанд манай ууган физикч- эрдэмтэд Г.Аюушжав, Н.Содном, Д.Батсуурь багш нар минь байжээ.

Эл давалгаан 40- өөд оны сүүлчээс 50- аад оны сүүлч хүртэл үргэлжилсэн юм. Ачтан багш нар минь харь газар шавилан сууж эрдэмтэд болоод ирцгээжээ. Тэд эрдмийг “өвөрлөсний” дээр “номын орны” үзэл санааны хур, жавар салхи татуулан ирцгээжээ. Тэр нь эрдэмд хорхойтож махран зүтгэх хүсэлтэй залуусын шинэ давалгааг түрэв.

Багш нарын маань эрч авахуулсан эрдмийн хоёр дахь давалгаа 60- аад оны бүр эхнээс өрнөв. Тэр давалгаан дунд өнхөрч, тэмтэрч, боссон бидний үеийнхэн өнөөдөр ахмадуудынхаа ачийг эргэн санахад сэтгэлд үнэнхүү таатай байна.

“Дэгжин” багш

Биднийг 2-р анги төгсөх хавар билүү дээ нэг өдөр манай ангийнхан нэг дэгжин эрдэмтэн багш шинээр иржээ гэгцгээж билээ. Тэгээд удалгүй нөгөө эрдэмтэн багш маань манай ангид хичээл орлоо. Тэр цагаас Д.Батсуурь багштай он удаан жил хамтран ажиллаж, физик эрдмийн далайд зүг чигээ заалгасан юм. Г.Аюушжав, Д.Батсуурь багш нар дэлхийн физик эрдмийн дэг жаягийг дагаж, манай ангийнхныг онол, хатуу бие, соронзны бүлэгт хувааж нарийн мэрэгжил олгох сургалтын салхийг хагалсан билээ. Сургуулиа төгсөөд эрдмийн сүмбэр уул- их сургуульдаа багшаар үлдэх ховорхон аз тохиосон нь багш нарын минь үнэлэмж, түшиг байсныг насан туршдаа санаж явдаг юм.

Тэдүүлсэн нь

Д.Цэрэн, Г.Очирбат багш нарын араас дагуулж онолын физик заах үүргийг Ба багш над өглөө. Онолын физик гэж юу болохыг ухаарсан юмгүй ер нь онолын физик гэж математикт суурилсан “цэцэн” ухаан байдаг тухай багш нараасаа сонсон “хорхойтож” дүүвээнээр давхижэ бас ч зүтгэж явсан гэнэн нас байлаа.

Харин Ба багш маань бид бүгдэд хичээлийг оноож бас зөвлөгөөнөө хайрладаг байлаа. Багшийн хэлсэн үгийг залуу багш нар бид “бурханы” номлол мэт дагадаг байсан юм. Надад атомын физик, квантын механикийн хичээл даалгаж олон жил заалгасан нь миний насан туршдаа зүрх сэтгэл, хүчээ зориулах мэрэгжил- үйлс болсон юмдаа. Багш маань яаж бодож оноосон юм болдоо.

Анхны юм амаргүй нь үнэн шүү. Ба багш биднийг хичээлдээ няхуур бэлдээрэй гэж үргэлж зөвлөнө. Бид ч “нэг” орос сурах бариад чадан ядан орчуулж, бас томъёоны гаргалгыг дориун хийж бэлтгэдэг байлаа. Нэг ёсноо оюутнуудад тэр сурах бичгийг унших “тэг” эрэмбийн бэлтгэлийг л хангадаг байлаа.

Нэг удаа хичээлээ их л “зоригтой” заагаад байлаа. Голдуу л оюутнууддаа бичүүлдэг байлаа. Нэг харах нь Ба багш оюутнуудын ард сууж байна. Орж ирэхий нь хараагүй юм санж. Тэгээд миний хичээл нэг л дэгэн догонттой болоод явчихлаа. Хичээл

дуусахаар Ба багшийг дагаад 309-рүүгээ очлоо. Намайг загнах байхдаа гэтэл хичээл чинь болж байна. Цаашид эрдмийн газар илтгэл тавьж таарна. Сандарч "тэнцвэрээ алдахгүй" өөрийнхөөрөө зоригтой ярьж байгаарай гэж зөвлөв. Тэр зөвлөгөө насан туршид намайг зоригжуулсан юм.

Тэр үед багш нарынхаа заасан номоор л хичээл заадаг. Заримдаа нэрлэсэн ном нь олддохгүй бол багш нараасаа авна. Ба багшийн нэрлэсэн ном олддохгүй болохоор нь багшийн дүү, оюутан Лхамсүрэнг чи олоод ир гэсэн чинь номыг нь аваад ирж. Хичээлээ зааж дуусаад багшид өгсөнд

-Чи миний номыг хэзээ авсан билээ гэв. Лхамсүрэн авчирж өгсөн юмаа гэвээс

-Тэгвэл Пушкин та хоёр хуйвалдсан байх нээ гэж шоглоом болгож билээ.

Чэгтан бул

Физикийн лабораторын ажлыг сэргээх, шинээр тавих ажлыг багш нарт хувиарлаж хийлгэдэг. Ямар багш юу хийж чадахыг яг цэгнээд оноож хийлгэдэг байлаа. Хуучин ажлын агуулахаас над Обербек дүүжингийн хуваарьт мод, чэгтан бул хоёрыг гаргаж өгөөд энэ ажлын хуучин зааврыг уншаад ажлыг тавь гэлээ. хананд тогтоодог бэхээр тодруулсан хувиартай мод нь одоо ч ажилд хэрэглэгдсээр харагддаг юм. Гараар секундомер дарж хийдэг "болхи" ажлыг маань Москвагийн их сургууль төгсч ирсэн Л.Дэмбэрэлд даалган сайжруулснаар хугацааг автоматаар хэмждэг болгосон юм. Түүнээс хойш ч Ба багш, Дэмбэрэл хоёр түүнийг дахин сайжруулсан юм билээ.

Буянтай үйлс.

Далаад оны дунд үед Ба багш нэг өдөр ерөнхий физикийн сурах бичиг хамтарч бичие гэлээ.

-Бичиж болно байхаа. Харин яаж хэвлүүлэх вэ? гэвэл

-Би хөөцөлдөнөө гэж товчхон хариулснаар бид хоёр "Молекуляр физик" хэмээх сурах бичиг туурвиж хэвлүүлсэн юм.

Энэ бүтээлд Ба багшийн минь шавиа дэмжиж бас итгэж, хамтран ажиллах гэсэн сэтгэлийнх нь дээжис шингэсэн дээ гэж бодож явдаг юм.

ЦШНИ-д ажиллаад эрдмийн дэд зэрэг хамгаалж ирсний дараа бидний судалгааны эхлэлийг дэмжиж төлөвшүүлэх гэж чармайдаг байлаа. Их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал байхдаа ЦШНИ-д эрдэмтдийн хамт туурвисан бүтээлийг Эрхүүгийн их сургуульд зориуд явуулан илтүүлсэн юм.

Ба багшийн үнэт зөвлөгөө, дэмжлэг хийгээд ЦШНИ-ийн анд эрдэмтдийн туслалцаатайгаар 1973 оноос Москвагийн их сургуулийн физикчидтэй холбоо тогтоов. Тэгээд он удаан жилийн хамтын ажиллагааны дүнд онолын физикээр монголын их сургуулиуд дундын эрдмийн шавь сургууль бүрэлдсэн юм. Ийм буянтай үйлсийг багш маань дэмжиж эхлүүлээд бэхжүүлсэн юм.

Багшийн сэтгэл

Намайг сургуульд багш болсны намар. Ба багш

- Чи ямаршүү тохижиж байна гэлээ.
- Оюутны байрын нэг өрөө авсан. Оюутныхаа ортой бас нэг тумбочк, ширээ, сандал авсан гэв.
- Хоол, хүнсний бас хувцсаа хийх сав байна уу? гэж асуухад нь
- Одоохондоо юм авч чадаагүй байгаа гэвэл
- Би хуучин модон шкаф өгөө. Нилээд өндөр юм хувцас хийвэл илүү тохиромжтой. Би багш болонгуутаал авсан юм гэв.
- Тэгээд хувцасны шкафтай болж гялайлаа. Түүнийг манайх 70- аад оны дунд үед л сольсондоо.

Дайлуулсан нь:

Ш.Гэрбиш, Б.Жаргал бид нарт Дубнад сууж ном үзэх аз тохиов. Ба багш дэмжиж, боломж гаргаж бас эрдмийн ирээдүйгээ харсан нь тодорхой. Ба багш Гэрбиш бид хоёрыг гэртээ урьж дайшлаа. Багш:

-ЗХУ-д дэлхийд нэртэй цөм судлалын төвд ном үзэх болсонд чинь баяр хүргэж байна. Та нарыг эрдэм, номын амьдралын сайхан ирээдүй унтаж байна. Биеэ дайчилж сайн ажиллаарай, хүний газар бас болгоомжтой яваарай гэж сургамж хайрлаад

-Орос оронд явах улс нэг нэг жүнз тогтоочих, цаашдаа бас суралцах л болно доо гэж билээ.

Тэгээд бид хоёрт тухайн үеийн бэлэг дурсгалын зүйл өгсөн юм. Дубнаад сууж байхад баяр ёслолын үеэр Багш маань мэндчилгээ ирүүлдэг байсанд их л баярлаж явлаа.

Ба багш маань амьдралынхаа чухал асуудалтай үед ч надад найдвар хүлээлгэдэг байсныг одоо нэхэн санахад сэтгэлд таатай байдаг. Далаад оны эхэн үед Ба багш Гэрэлмаа, Самдан багш бид тэрэлжид хамтаараа нэг сайхан амарч байсан маань санаанд илхэн байна. Тэндээс багшийн маань

амьдралд нэг шинэ үе эхэлснийг би мэднэ. Хүү Хашаатай нь уулзах болгондоо багшийн маань сэтгэл баясгалантай явсан үеийг дурсан санадаг.

Алтан гадсыг угаасан нь:

Далан хэдэн онд багш маань төрийн дээд шагнал алтан гадсаар шагнуулсан юм. Бид шавь нар нь тэр одонг даруухан угааж

байснаа санаж байна. Мөнх бусын үйл дайраагүй бол багш маань бие тэнхэл сайтай, тайван дөлгөөн урт наслах хүн байсан гэж боддог. Бүтээсэн сэтгэсэн гэгээн үйлсийг нь бодохоор Д.Батсуурь багш бол гарцаагүй л манай улсын гавьяат цолтны нэг байх байсандаа гэж бодогддог юм.

О. Лхагва

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн
МУИС-ийн профессор

Нью Йоркийн ШУА-ийн жинхэнэ гишүүн,

Шугаман бус эрдмийн дэлхийн академийн жинхэнэ гишүүн,

ХХ зууны дэлхийн 2000 шилдэг эрдэмтний дипломт,

Дэлхийд хэний хэн бэ толь бичигт данстай,